# ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.

**АГУУЛГА**


**Нэг. Бодлогын зорилтыг хангах талаар**

1.1. Удирдлага зохион байгуулалтын талаар
1.2. Хэлтсийн алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр
1.3. Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, байгууллагын нээлттэй байдлыг хангах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн
1.4. Мэдээлэл технологийн чиглэлээр
1.5. Байгууллагын дотоод ажлын чиглэлээр
1.6. Аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэлээр
1.7. Тайлан мэдээ, албан бичгийн талаар
1.8. Санхүү Үнэт цаас, тооцоо үйлчилгээний талаар

**Хоёр Иргэний бүртгэлийн үйл ажиллагааны тайлан**

2.1 Иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжийг аймгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулах ажлын чиглэлээр
2.2.Иргэний улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу аймгийн хэмжээнд эрхлэн хөтлөх, хяналт тавих чиглэлээр:
2.3. Иргэний баримтын архивын сан бүрдүүлэлтийн чиглэлээр
2.4. Иргэний улсын бүртгэгч нарыг өдөр тутамд нэгдсэн арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллах чиглэлээр
2.5. Иргэний бүртгэлийн чиглэлээр хэрэгжүүлсэн шинэлэг ажлуудаас:

**Гурав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар**

3.1. Төсөв санхүүгийн чиглэлээр
3.2. Хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр
3.3. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлууд:
3.4. Хууль тогтоомж сурталчилах ажлын чиглэлээр
3.5. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн үүрэг чиглэл, дотоод ажлын талаар
3.6. Цаашид анхаарах тулгамдаж буй асуудлын талаарх санал

**Дөрөв. Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааны талаар**

4.1. Хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагааны талаар
4.2. Сургалт сурталчилгаа, хууль сурталчлах ажлын хүрээнд
4.3. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэх ажлын хүрээнд

**Тав. Бүртгэлийн хяналтын чиглэлээр**

5.1. Бүртгэл хяналтын чиглэлээр хийсэн ажлын ерөнхий мэдээлэл

5.2. Иргэний улсын бүртгэлд хяналт шалгалтын чиглэлээр

5.3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хяналт тавих чиглэлээр

5.4.Хуулийн этгээдийн бүртгэлд хяналт тавих чиглэлээр

**Зургаа. Мэдээлэл, технологийн чиглэлээр**

6.1 Хэлтсийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашигладаг тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийсэн байдал:

6.2 Сумдын тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийсэн байдал

*6.3* Сумдын тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийсэн байдал*:*

## НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

1.1.Удирдлага, зохион байгуулалтын талаар:

2021 онд Улсын бүртгэлийн ерөнхий газраас баталсан орон тооны дагуу хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч-1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч-2, улсын бүртгэгч-30, архивч-2, хяналтын улсын байцаагч-1, нярав-бичиг хэргийн ажилтан-1, мэдээлэл технологийн ажилтан-1, нягтлан бодогч-1, угтах үйлчилгээний ажилтан-жолооч-1 /гэрээт/, үйлчлэгч-1 /гэрээт/ гэрээт ажилтан гэсэн нийт 41 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Хэлтсийн дарга нь байгууллагынхаа төрийн үйлчилгээний алба хаагчидтай хөдөлмөрийн гэрээ, төрийн захиргааны алба хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус байгуулан ажиллаж байна. Түүнчлэн Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, Хүний эрхийг хангах төлөвлөгөө, Жендерийн эрх тэгш байдлыг хангах 2021 оны ажлын төлөвлөгөө /Жендэр-ӨВ дэд хөтөлбөртэй уялдуулан/, Терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө, Эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, төрийн албаны тухай хуулийг салбарын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Эрх зүй сургалт, сурталчилгааны ажлын 2021 оны төлөвлөгөө, Ил тод, нээлттэй байдлын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус батлан нэг, нэг албан хаагчдад хариуцуулан хэрэгжилтийг тухай бүр нь тайлагнан ажиллаж байна.

1.2. Хэлтсийн алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр:

Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж 5 ажилтанд ур чадварын нэмэгдлийг 25 хувиар олгохоор шийдвэрлэж олгоод байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж хэлтсийн үйлчилгээний заалыг засварлаж, эд хөрөнгийн архивын өрөөг өргөтгөсөн. Хамтран ажилладаг барилгын компаниудын тусламж дэмжлэгээр эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн өрөөг 2 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалын тусламжтайгаар засварлуулсан.

Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсэд 1200 мкв газар эзэмших асуудлыг Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлж 2022 оны төсөвт 1.5 тэрбум төгрөгийг тусгуулахаар ажиллаж байна. Хэлтсийн хаягийг шинэчилж кирилл болон үндэсний бичгээр хослуулан хаягжуулалтыг хийгээд байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр нийгмийн хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт 2 сканер /Canon DR-M260/, Хайрхандулаан, Нарийнтээл сумдад Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдоход юнителийн 4G модем 2 ширхэг, улсын төсвөөс Хархорин сумын иргэний бүртгэгчид Канон-3010 маркийн үйлдэлт принтерийг хүлээлгэн өгч үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

"Гэрэгэ Системс" ХХК-тай гэрээ байгуулж "D" киоскыг манай хэлтэст үнэгүй тавихаар болсон. 11 сарын 23-ны өдөр гэрээний гүйцэтгэл явагдах төлөвлөгөөтэй байсан боловч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хойшлогдсон.

COVID-19 буюу короновирусын дэгдэлтээс Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг тусгай горимд шилжүүлж ажилласан бөгөөд албан хаагчдад 383,000 мянган төгрөгний үнэ бүхий витамин, ариутгалын хэрэгсэл, 4 удаа нэг удаагийн амны хаалтаар хангасан. УБЕГазраас 18 сая төгрөгийн үнэ бүхий амны хаалт, 1176000 төгрөгийн өртөг бүхий санитол, 30000 төгрөгийн үнэ бүхий малгай, 225000 төгрөгийн үнэ бүхий нүүрний хаалт, 300000 төгрөгийн цэвэрлэгээний тоног төхөөрөмж, 750000 төгрөгийн ариутгалын тоног төхөөрөмж 5 ширхэг тус тус ирээд байна. Мөн ЗООНОЗ өвчин судлалын төвтэй хамтран хэлтсийг байрыг ариутгалтын бодисоор 3 удаа халдваргүйжүүлэн ажилласан.

Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар нийгмийн хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд Хайрхандулаан, Нарийнтээл сумдыг улсын бүртгэлийн онлайн системд холбон бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж ажиллаж байна. Бат-Өлзий сумыг 2017 онд онлайн сүлжээнд холбосон боловч ЗДТГ-ын байр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор сүлжээ тавих асуудал цуцлагдсан байна. Нийт 18 сумд онлайнд хамрагдан 95 хувийн үзүүлэлттэй байна.

1.3 Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, байгууллагын нээлттэй байдлыг хангах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн:

Улсын бүртгэлийн хөдөлмөрийн дотоод журам шинэчлэлтэй холбоотой саналд хэлтсээс 2 санал хүргүүлснээс 1 санал нь тусгагдан батлагдсан ба дотоод журмыг нийт алба хаагчдад танилцуулан гарын үсэг зуруулан албажуулсан. Төрийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн талаар сургалтыг бүртгэлийн болон итгэмжлэгдсэн ажилтанд 2021 оны 05 сарын 12-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Үйлчилгээний стандартыг өдөр тутамдаа мөрдөн ажиллах талаар алба хаагчдад сурталчлан энгэрийн тэмдэг, үсний даруулга, бүртгэлийн үйлчилгээний ажилтнуудын болон бүртгэлийн төрөл тус бүрээр стандартад нийцсэн танилцуулга самбарыг хийж байршуулсан.

Бүртгэлийн онлайн сүлжээнд тус аймгийн 18 сум бүрэн холбогдож, сумын бүртгэгчдэд онлайн сүлжээнд ажиллах эрхийг нээлгэсэн ба иргэний бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг онлайн сүлжээнд бүртгэж, бүх төрлийн лавлагааг сумандаа гарган иргэдэд түргэн шуурхай үйлчилж байна. Улсын бүртгэлийн 18 төрлийн үйлчилгээ, 20 төрлийн лавлагааны төлбөрийг ebarimt ашиглан төлөх боломж бүрдэж иргэдэд мэдээллийг хүргэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласнаар нийт 28 иргэн цахим төлбөрийн системийг ашиглаж, төлбөрийг цахимаар баталгаажуулав. Иргэн УБЕГазрын BURTGEL.MN сайтаар цахим архивын лавлагаа олгох программаас 14 төрлийн лавлагааг цахимаар хүлээн авах боломжийн талаар иргэдэд сурталчилгаа мэдээллийг хүргэж ажилласны үр дүнд иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн, хаясан гээгдүүлсэн иргэд /нийт 4 иргэн/ цахимаар захиалж баталгаажуулсан. Бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон 18 сумын бүртгэгч цахим архив ашиглах бүх төрлийн лавлагааг цахим архиваас гарган нотлох баримтандаа авч ашиглаж байна.

Улсын бүртгэгч албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, холбогдох сургалтуудад оролцуулах, шинээр томилогдсон улсын бүртгэгч нарыг сургах, дадлагажуулах ажлыг тодорхой төлөвлөгөө, хөтөлбөртэйгөөр хэрэгжүүлж ажиллав.

Сургалт сурталчилгааны чиглэлээр:

Тайлант хугацаанд УБЕГ-аас эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 4 онлайн сургалт, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2 сургалт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1, аймгийн Төрийн албаны зөвлөлөөс 1 онлайн, жендерийн чиглэлээр 1, сонгуулийн холбогдолтой 2 онлайн сургалтад тус хамрагдсан. Хэлтсийн хэмжээнд "Үндэсний бичиг-2025" хөтөлбөрийн хүрээнд 20 алба хаагч 2 ангид хуваарилагдан нийт 21 цагийн сургалтад хамрагдаж байна. Угийн бичиг хөтлөх аянд нэгдэж багш М.Үүрцайхын сургалтад 17 алба хаагч хамрагдаад байна. Үр дүнд суурилсан төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ сэдэвт цахим сургалтад нийт 4 алба хаагч хамрагдан сертификат авсан.

Хэлтсийн 2021 оны 02 сарын 16-ны өдөр Хэлтсийн алба хаагчдын сургалтын 9 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг 45 хувиар хангаж ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 13 дугаар тойргийн хэсгийн хороонд ажиллах итгэмжлэгдсэн ажилтны сургалтын хөтөлбөрийг хэлтсийн даргаар батлуулан, итгэмжлэгдсэн ажилтнуудад хөтөлбөрийг цахимаар зохион байгуулав. Сургалтыг хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, МТАжилтан, ня-бо нар зохион байгуулж явуулав. Төрийн нууц, Албаны нууцын тухай хууль тогтоомж, мэдээллийн сангийн аюулгүй байдлын талаар аймаг дахь Тагнуулын хэлтсийн ажилтан Ч.Ууганбаяр мэдээлэл өгч хамтран ажилласан.

Иргэний улсын бүртгэгч /19 сумын/ нарыг 4 хэсэгт хуваан иргэний бүртгэлийн системд цахим архивыг хэрхэн ашиглах, лавлагааг гаргах, иргэний улсын бүртгэлийн шинэ системд дадлага туршилт хийх зөвлөмж, зааврыг, иргэний улсын бүртгэл дээр гарч буй алдаа түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг хорио цээрийн дэглэмийн үед тогтоосон журмыг баримтлан, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллав. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны ирц бүртгэлийн программын сургалтыг зохион байгуулах ажлыг УБЕГазраас сургалтын багийнхантай хамтран зохион байгуулав. 110 хэсгийн хороонд ажиллах 110 итгэмжлэгдсэн ажилтныг оролцуулсан.

1.4 Мэдээлэл технологийн чиглэлээр:

Арвайхээр, сумын улсын бүртгэгчийн албан хэрэгцээнд ашигладаг Canon 1000D маркийн зургийн аппарат ажиллахгүй болсныг шалгуулан засварлах боломжгүй тул Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газар болон санхүү, төлөвлөлтийн газарт хандан шинэ аппаратаар солиулан тохиргоог хийлгэн хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

Хайрандулаан, Нарийнтээл сумдыг онлайн сүлжээнд холбуулан нийт аймгийн хэмжээнд 18 сумдыг онлайнд холбож иргэд газар дээрээс нь бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөл боломжийг хангаад байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасагт УБЕГазраас CANON маркийн 2 скайнер шийдэж өгсөн.

Хэлтсийн нэгдсэн сургалт семинар, Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулж байгаа онлайн сургалт болон сумдын бүртгэгч нарийн бүсчилсэн сургалтын үеэр Civilreg.offline программын шинэчлэл, компьютерын ашиглалтын талаар зөвлөмж өгүүлж эвдрэлтэй ирсэн тоног төхөөрөмжийг засварлуулав.

Дотоод нөөц бололцоонд тулгуурлан засварлах боломжтой сумдаас ажиллахгүй болж ирсэн техник тоног төхөөрөмжийг цаг тухай бүрт засуулан хүргүүлэв.

1.5 Байгууллагын дотоод ажлын чиглэлээр:

Тус хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг батлагдсан төсвийн хүрээнд үр ашигтай, өр авлагагүй зарцуулан ажиллаж байна. Мөн шилэн дансны мэдээлэлд хяналт тавин баталгаажуулан ажиллаж байна.

Тус хэлтсийн төрийн захиргааны алба хаагчдаас ХАСХОМ-ийг цахим системд шинэчлэн гаргуулж баталгаажуулан хүргүүлэв.

Төрийн захиргааны алба болон үйлчилгээний алба хаагчдын хүний нөөцийн нэгдсэн судалгааг гаргуулан хүргүүлсэн.

Хүний нөөцийн талаарх мэдээ, мэдээллийг шинэчлэгдсэн тухай бүрт нь hr.csc.gov.mn Хүний нөөцийн систем нэгдсэн программд оруулж хагас жилийн байдлаар мэдээллийг нягтлан шалгаж дахин оруулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 5 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан Төрийн алба хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу шинээр томилогдсон алба хаагчийн төрийн алба хаагчийн анкет, хувь хүний намтрыг гаргуулан УБЕГазарт тухай бүр хүргүүлэн ажилласан.

Долоо хоног бүрийн Мягмар гарагт аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлаг цаг үеийн мэдээ, мэдээллийг солилцон хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах, авч хэрэгжүүлэх ажлын саналаа хэлэлцдэг шуурхай хуралдаанд тогтмол оролцож, тухайн мэдээллийг хэлтсийнхээ дарга нарын зөвлөлийн хурлаар танилцуулан ажиллаж байна.

Хэлтсийн хэмжээнд нийт 6 удаагийн хурал зөвлөгөөнийг хийж цаг тухай бүр алба хаагчиддаа үүрэг, чиглэл өгч удирдлагаар хангаж ажиллалаа.

Иргэдтэй хуваарийн дагуу уулзан санал бодлыг нь сонсон ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулахын тулд орон нутгаас 7 сая төгрөг шийдүүлж, засвар үйлчилгээ хийсэн. Үйлчилгээний танилцуулга салбар шинээр хийж байршуулсан. Байгууллагын хаягжуулалтыг хос бичгээр стандартад нийцсэн загвараар хийлээ.

1.6 Аюулгүй байдлыг хангаж ажиллах чиглэлээр:

Хэлтсийн аюулгүй байдлыг хангаж үүднээс дохиоллын систем болон хөдөлгөөн мэдрэгчийг бүрэн бүтэн байдлыг ханган гадны халдлага болон гал усны аюул зэргээс урдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хянан ажиллаж байна.

Амралт, баяр ёслолын өдрүүдэд хэлтсийн аюулгүй байдлыг ханган ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг хагас жилээр гаргаж амралтын бямба, ням гарагт алба хаагчдыг ээлжээр эргүүлээр ажиллуулж байна.

1.7 Тайлан мэдээ, албан бичгийн талаар:

Тайлант хугацаа /2021 оны 06 сарын 15-ны өдрийн байдлаар/-нд нийт албан бичиг 796 ирж, 456 албан бичгийг холбогдох газруудад явуулж, албан хэрэг хөтлөлтийн стандарт заавар журмын дагуу бүртгэлжүүлж ажилласан.

Ирсэн албан бичгийг дотор нь ангилж үзвэл дээд газраас /Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Засаг даргын тамгын газар, хэлтэс албадаас /-244, Хууль хяналтын байгууллагаас-92, бусад хэлтэс, агентлаг, албан байгууллагаас 460 албан бичиг ирсэн байна.

Тайлант хугацаанд хариутай 203 бичиг ирснийг бүртгэлд аван бүртгэл хяналтын карт хөтлөн албан бичгийг хугацаанд нь хүргүүлсэн байна. Тайлангийн хугацаанд хууль хяналтын байгууллагаас 92 албан бичиг ирснээс эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 28, иргэний бүртгэлийн 35, хуулийн этгээдийн бүртгэлээр 8 лавлагаа, эрх түдгэлзүүлэх 8, эрх сэргээсэн 5, бусад 8 албан бичиг гарган хүргүүлэв.

Явуулсан албан бичгийг дотор нь ангилж үзвэл дээд шатны байгууллагад /Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Засаг даргын тамгын газар/-192, Хууль хяналтын байгууллагад 118, аймгуудын хэлтэс, бусад агентлаг, албан байгууллага, иргэдэд 146 албан бичгийг стандарт зааврын дагуу боловсруулан бүртгэл хөтлөн ажилласан.

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой сар бүрийн мэдээ, хяналтын улсын байцаагчийн сарын ажлын тоон мэдээ, санхүүгийн болон үнэт цаасны сар, улирлын мэдээ, тайлан, өргөдөл, гомдлын мэдээ зэргийг нэгтгэн гаргаж, тогтоосон хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна. Ажлын байрны тодорхойлолтод тусгаж баталгаажуулсны дагуу Хэлтсийн орон тоон дээр шинээр томилогдсон албан хаагчийг бүртгэж, хувийн хэрэг нээж, хэлтсийн ажилчдын хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний судалгаа тайланг шинэчлэн гаргасан. Архив албан хэрэг хөтлөлтийн Able программ дээр ирсэн, явсан өргөдөл гомдлыг цаг тухай бүрт нь бүртгэн ажиллаж байна. Мөн төрийн байгууллагын цахим шуудан болох email –ийг ашиглан мэдээлэл солилцон мэдээллийн сан үүсгэн лавлагаа, мэдээ тайланг хүлээн авах, яаралтай албан тоотыг хүргүүлэх, хүлээж авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

| Сар | Ирсэн бичиг | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт дүн | | Хууль хяналтын байгууллагаас бусад нийт | Үүнээс | | | | | | | | | | | | |
| | | | | Хууль хяналтын байгууллагаас бүгд | Үүнээс | | | | | | сумдын ЗДТГазраас | Аймгийн ЗДТГазар, хэлтэс албад | УБЕГазраас | Бусад аймаг УБХэлтсээс | Нийслэлийн Улсын бүртгэлийн газраас | Бусад |
| | Бүгд | Хуудасны тоо | | | Шүүх | Прокурор | Цагдаа | АТГ | ТЕГ | ШШГГ | | | | | | |
| УБХ | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 1 | 168 | - | 136 | 32 | 4 | 26 | 2 | - | - | 17 | 52 | 17 | 28 | 16 | 3 | 3 |
| 2 | 154 | - | 143 | 11 | - | 6 | 3 | - | - | 2 | 63 | 23 | 31 | 17 | 5 | 4 |
| 3 | 110 | - | 106 | 6 | 4 | - | - | - | - | 2 | 48 | 9 | 31 | 14 | 1 | 1 |
| 4 | 136 | - | 127 | 11 | 5 | 1 | 3 | - | - | 2 | 70 | 13 | 26 | 15 | 1 | - |
| 5 | 151 | - | 130 | 21 | - | 4 | 6 | - | - | 11 | 43 | 14 | 32 | 21 | 5 | 15 |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 77 | - | 66 | 11 | - | 5 | - | - | - | 6 | 31 | 6 | 14 | 8 | 1 | 6 |
| **Нийт** | 796 | - | 708 | 92 | 13 | 42 | 14 | - | - | 40 | 307 | 82 | 162 | 91 | 16 | 29 |

| Сар | Явсан бичиг | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт дүн | | | | Үүнээс | | | | | | | | | | | |
| | | | | | Үүнээс | | | | | | | | | | | |
| | Бүгд | Хуудасны тоо | Иргэдэд албан бичгээр хүргүүлсэн лавлагаа | Хууль хяналтын байгууллагад бүгд | Шүүх | Прокурор | Цагдаа | АТГ | ТЕГ | ШШГА | сумдын ЗДТГазарт | Аймгийн ЗДТГазар, бусад албадад | УБЕГазарт | Бусад аймгийн УБХэлтэст | Нийслэлийн Улсын бүртгэлийн газарт | Бусад |
| УБХэлтэс | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо | тоо |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 1 | 109 | - | - | 43 | 4 | 24 | 2 | - | 2 | 11 | 2 | 6 | 36 | 20 | 2 | - |
| 2 | 65 | - | - | 12 | - | 9 | 2 | - | - | 1 | - | 8 | 30 | 9 | 2 | 4 |
| 3 | 80 | - | - | 8 | 5 | - | 1 | - | - | 2 | - | 8 | 26 | 31 | 2 | 5 |
| 4 | 80 | - | - | 12 | 7 | 3 | - | - | 1 | 1 | 19 | 9 | 28 | 4 | 2 | 6 |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 87 | - | - | 24 | - | 3 | 12 | - | 6 | 3 | - | 7 | 24 | 23 | 2 | 7 |
| 6 | 35 | - | - | 19 | - | 5 | - | - | 1 | 13 | - | 3 | 7 | 5 | 1 | - |
| **Нийт** | **456** | **-** | **-** | **118** | **16** | **44** | **17** | **-** | **10** | **31** | **21** | **41** | **151** | **92** | **11** | **22** |

**Улсын бүртгэлийн хэлтэст иргэдээс хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол санал хүсэлтийн агуулга /хувиар/ /2021 оны хагас жилийн байдлаар/ 2021.06.15**

| № | Агуулга | | Тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **1** | **Өргөдлийн агуулга** | 1. Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар /төрөлт, нас баралт, иргэний нөхөн бүртгэл хийлгэх, лавлагаа, хуулбар, гэрчилгээ авах, гадаад паспорт, гадаадын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлтэй холбоотой / | **9** | **13.6 3%** |
| | | 2. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар /Орон сууцны жагсаалт гаргах гэх мэт/ | **1** | **1.51%** |
| | | 3. Хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой /Лавлагаа авах, хуулбар авах гэх мэт / | **0** | **0%** |
| | | 4. Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар /Иргэний баримт бичгийн болон бусад бүртгэлийн зөрчил арилгуулах, хүчингүй болгуулах, шалгуулах, хориг цуцлуулах, залруулах, дүгнэлт гаргуулах/ | **31** | **46.96%** |
| | | 5. Төрийн үйлчилгээний цахим машинтай холбоотой асуудлаар /ТҮЦ машинаас олгосон лавлагаагаар бусад байгууллага үйлчлэхгүй байгаа г.м/ | **0** | **0%** |
| | | 6. Иргэний цахим үнэмлэх, шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой асуудлаар | **0** | **0%** |
| | | 7. Ажлын байр болон албан хаагчидтай холбоотой асуудлаар /ээлжийн амралт, чөлөө, тэтгэмж, тусламж хүссэн, ажлаас чөлөөлөгдөх, тодорхойлолт хүсэх, зэрэг дэв, цалингийн шатлал нэмүүлэх гэх мэт/ | **23** | **34.84%** |
| | | 8. Бусад | **2** | **3.03%** |
| | | **Нийт** | **66** | **100%** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2** | **Гомдлын агуулга** | 1.Тухайн газар, хэлтсийн ерөнхий үйл ажиллагаатай холбоотой | | |
| | | 2. Иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой | | |
| | | 3. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой | | |
| | | 4. Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой | | |
| | | 5. Бүртгэлийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой | | |
| | | 6. Албан хаагчдын зан харьцаатай холбоотой | | |
| | | 7. Бусад | | |
| | | **Нийт** | **-** | **-** |

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ**

| № | Ангилал | | Өргөдөл шийдвэрлэлт | | | | | | Гомдол шийдвэрлэлт | | | | | | Санал, хүсэлт шийдвэрлэлт | | | | | | Талархал | Шүүмжлэл | Нийт дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хугацаа | | | | | | Хугацаа | | | | | | Хугацаа | | | | | | | | Хугацаа | | |
| | | | 1. Шийдвэрлэсэн | 2. Бусад байгууллагад шилжүүлсэн | 3. Шийдвэрлээгүй / хугацаа болоогүй/ | 4.Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн | 5. Хугацаа сунгасан | **Нийт** | 1. Шийдвэрлэсэн | 2. Бусад байгууллагад шилжүүлсэн | 3. Шийдвэрлээгүй / хугацаа болоогүй / | 4.Хугацаандаа хэтэрч шийдвэрлэсэн | 5. Хугацаа сунгасан | **Нийт** / 1+2+3 / | 1. Шийдвэрлэсэн | 2. Бусад байгууллагад шилжүүлсэн | 3. Шийдвэрлээгүй / хугацаа болоогүй / | 4.Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн | 5. Хугацаа сунгасан | **Нийт** / 1+2+3 / | | | 1. Шийдвэрлэсэн | 2. Бусад байгууллагад шилжүүлсэн | 3. Шийдвэрлээгүй / хугацаа болоогүй / | 4.Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн | 5. Хугацаа сунгасан | **Нийт** / 1+2+3 / |
| 1 | Хэлбэр | Бичгээр | **47** | **0** | **19** | **0** | **0** | 66 | | | | | | | | | | | | | | | **47** | | **19** | | | **66** |
| | | Биечлэн хандсан | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | “11-11 мэдээллийн | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төв"-өөр | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Цахим хуудас дахь "Зочны дэвтэр"-ээр | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Мессенжер, фейсбүүк хаягаар | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Утсаар хандсан | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Аймгийн "Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Нийт | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Субъект | Иргэн | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Хуулийн этгээд | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | УБЕГ-ын албан хаагч | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |

1.8.Санхүү, үнэт цаасны тооцоо, үйлчилгээний талаар:

**САНХҮҮ, ҮНЭТ ЦААСНЫ ТООЦОО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР**

**2021ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН** *I2021оны 2дугаар улирлын байдлаар 218,431,600/мян.төг/*

| **Зардлын дүн** | **Батлагдсан төсөв** | **Төсвийн гүйцэтгэл** |
|---|---|---|
| **Нийт зарлагын дүн** | **218,431,6** | **215,976.6** |
| *Цалин, хөлс болон нэмэгдлийн дүн* | **201,628.8** | **201,628.8** |
| Үндсэн цалин | 141,869.5 | 154,480.7 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 4,290.0 | 4,189.9 |
| Нэмэгдэл | 27,074.2 | 14,563.0 |
| **АО-с төлөх НДШимтгэлийн дүн** | **28,395.1** | **28,395.1** |
| Нийгмийн даатгалын шимтгэл | **28,395.1** | **28,395.1** |
| **Бараа үйлчилгээний зардлын дүн** | **16,802.8** | **14,347.8** |
| Бичиг хэрэг | 1,734.0 | 1,582.5 |
| Гэрэл цахилгаан | 2.107.2 | 1,033.7 |
| Түлш халаалт | 7,468.0 | 7,721.4 |
| Тээвэр шатахуун | 826.6 | 826.6 |

| | | |
|---|---|---|
| Шуудан холбоо | 1,045.6 | 1,027.0 |
| Цэвэр бохир ус | 1,387.2 | 389.4 |
| Дотоод албан томилолт | 20.8 | 0.0 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал | 468.0 | 292.0 |
| Багаж техник хэрэгсэл | 182.0 | 182.0 |
| Хөдөлмөр хамгаалалын хэрэглэл | 100.0 | 75.0 |
| Урсгал засвар | 65.0 | 0.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон шавьж устгах зардал | 14.3 | 0.0 |
| Бага үнэтэй түргэн элэгдэх зардал | 607.9 | 595.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ | 514.2 | 482.2 |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох | 0.0 | 0.0 |
| Тээврийн хэрэгслийн даатгал | 120.0 | 54.4 |
| Тээврийн хэрэгсэлийн татвар | 120.0 | 64.3 |
| Тээрийн хэрэгслийн оношилгоо | 22.0 | 22.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.0 | 0.0 |

## ӨР АВЛАГЫН БАЙДАЛ

| 1 | Байгууллагын нэр | Үйлчилгээний төрөл | Өр авлагын хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Сангийн яам | авлага | 128,026.00 | 2012 оны санхүүгийн тайланд үүссэн Он дамжсан авлага |
| 2 | Өвөрхангай нийгмийн даатгалын хэлтэс | Өр төлбөр | 9,623,765.00 | Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг |

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Тус хэлтсийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн УИХурлын сонгуулийн бэлтгэл ажлын санхүүжилтээр 37,207,600.00 төгрөгийн нэмэлт санхүүжилтүүд орж ирснийг хуулийн дагуу нэмэлт төсвийн эрхийг нээлгэн журмын дагуу зарцуулсан болно.

## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Тус хэлтэс нь 2021 онд улсын төсөвт нийт 118,354,688.90 мөнгөний орлого орсноос эд хөрөнгийн эрхийн бүртгэлээр 74,001,886.9төгрөг, 43,789,800 иргэний бүртгэлийн чиглэлээр, хуулийн этгээдийн бүртгэлээр 773,000 төгрөгийг тус тус оруулаад байна.

Орон нутгийн тэмдэгтийн хураамжийн орлого 17,676,700 төгрөг, хүү торгуулийн орлого 620,000төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдсаны татвар 13,977,553 төгрөгийг тус тус оруулаад байна.

## ҮНЭТ ЦААС ЗАРЦУУЛАЛТЫН ҮЛДЭГДЭЛ

| Үнэт цаас | | | |
|---|---|---|---|
| **Д/д** | **Нэрс** | **Хэмжих нэгж** | **Тоо ширхэг** |
| 1 | Бичвэргүй ИУБ /Үндсэн бүртгэл/ | ширхэг | 1000 |
| 2 | ИУБ- 22 /шилжилт хөдөлгөөн/ | ширхэг | 1100 |
| 3 | ИУБ-21 /ИҮО хуудас/ | ширхэг | 1800 |
| 4 | ИУБ-31 | ширхэг | 1401 |
| 6 | Төрсний гэрчилгээ | ширхэг | 650 |
| 7 | Төрсний гэрчилгээний хавтас | ширхэг | 750 |
| 8 | Нас барсны гэрчилгээ | ширхэг | 89 |
| 9 | Гэрлэлтийн гэрчилгээ | ширхэг | 1181 |
| 10 | Гэрлэлтийн гэрчилгээний хавтас | ширхэг | 520 |
| 11 | Лавлагааны маягт А4 | ширхэг | 140 |
| 12 | Лавлагааны маягт А5 | ширхэг | 3250 |
| 13 | Гэрчилгээ-Үл хөдлөх | ширхэг | 1550 |
| 14 | Гэрчилгээ-Газар | ширхэг | 1500 |
| 15 | Хөдлөх хөрөнгийн гэрчилгээ | ширхэг | 93 |
| 16 | Салбарын гэрчилгээ | ширхэг | 7 |
| 17 | Төлөөлөгчийн салбарын гэрчилгээ | ширхэг | 10 |

| | | | |
|---|---|---|---|
| 18 | Шийтгэлийн хуудас | ширхэг | 950 |
| 19 | Улсын байцаагчийн акт | ширхэг | 80 |
| 20 | Улсын байцаагчийн дүгнэлт | ширхэг | 500 |
| 21 | Улсын байцаагчийн албан шаардлага | ширхэг | 80 |
| 22 | Улсын байцаагчийн мэдэгдэл | ширхэг | 80 |
| 23 | Улсын бүртгэлийн гэрчилгээ | ширхэг | 100 |
| 24 | Хувийн хэрэг | ширхэг | 800 |
| 25 | Хувийн хэргийн хавтас | ширхэг | 800 |
| 26 | Мэдүүлэг иргэн | ширхэг | 500 |
| 27 | Албан тоот А5 | ширхэг | 0 |
| 28 | Албан тоот А4 | ширхэг | 1900 |
| 29 | Тушаалын бланк | ширхэг | 1000 |
| 31 | Гадаад паспортын мэдүүлгийн хуудас | ширхэг | 1670 |
| 32 | Хайрцган хавтас цэнхэр | ширхэг | 0 |
| 31 | Архивын бор дугтуй | ширхэг | 12000 |
| 32 | ХААТР 10 | ширхэг | 350 |
| 33 | ХААТР 11 | ширхэг | 500 |
| 34 | ХААТР 12 | ширхэг | 500 |
| 35 | ХААТР 14 | ширхэг | 200 |

| | | | |
|---|---|---|---|
| 36 | ХААТР 15 | ширхэг | 300 |
| 37 | ХААТР 16 | ширхэг | 450 |
| 38 | ХААТР 18 | ширхэг | 400 |

| **Бүртгэлийн дэвтэр** | | | |
|---|---|---|---|
| **Д/д** | **Нэрс** | **Хэмжих нэгж** | **Тоо ширхэг** |
| 1 | Аймаг нийслэлрүү шилжин явсан бүртгэлийн дэвтэр | ширхэг | 40 |
| 2 | Аймаг нийслэлээс шилжин ирсэн бүртгэлийн дэвтэр | ширхэг | 21 |
| 3 | Гэрлэлт цуцлалтын бүртгэлийн дэвтэр | ширхэг | 21 |
| 4 | Гэрлэлтийн бүртгэлийн дэвтэр | ширхэг | 21 |
| 5 | Гэрлэлтийн гэрчилгээ дахин дахин олгох бүртгэлийн дэвтэр | Ширхэг | 21 |
| 5 | Иргэний үнэмлэх дахин олгох бүртгэлийн дэвтэр | ширхэг | 36 |
| 6 | Нас баралтын бүртгэлийн дэвтэр | ширхэг | 21 |
| 7 | Овог нэр өөрчлсөний бүртгэлийн дэвтэр | ширхэг | 25 |
| 8 | Төрсний бүртгэлийн дэвтэр | ширхэг | 24 |
| 9 | Хүүхэд үрчилсэний бүртгэлийн дэвтэр | ширхэг | 22 |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Эцэг тогтоосны бүртгэлийн дэвтэр | ширхэг | 17 |
| 11 | Иргэний үнэмлэхийн дэвтэр | ширхэг | 25 |
| 12 | ЭХАрхивт хүлээлгэн өгөх дэвтэр | ширхэг | 17 |
| 13 | Бүртгэлийн дэвтэр | ширхэг | 5 |
| 14 | Лавлагаа олголтын бүртгэлийн дэвтэр | ширхэг | 5 |
| 15 | Архиваас түр олгох хуулийн этгээдийн хувийн хэргийн бүртгэлийн дэвтэр | ширхэг | 1 |
| 16 | Архиваас түр ашиглуулахаар олгосон иргэний баримтын бүртгэлийн дэвтэр | ширхэг | 1 |
| 17 | Улсын бүртгэлд шинээр бүртгэгдсэн хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт хүлээн авах бүртгэлийн дэвтэр | ширхэг | 1 |
| 18 | УБ-15 /Хураан авсан тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн бүртгэл / | ширхэг | 1 |
| 18 | УБ-17 | ширхэг | 4 |
| 19 | Маягт А̀2 /архиваас түр олгох, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн бүртгэл / | ширхэг | 8 |
| 20 | Маягт А̀3 /ЭХЭУБ-ийн хувийн хэрэг , нотлох баримтанд криминалистик шижилгээ хийгдсэн тухай бүртгэл / | ширхэг | 4 |
| 21 | А 12 ЭХЭУБүртгэлийн газрын тамга тэмдэг олгох, хураан авах хадаглах, хүчингүй болгосон тухай бүртгэл | ширхэг | 2 |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | ЭХЭУБ-ийн хувийн хэрэг архивт хүлээн авах дэвтэр | ширхэг | 16 |
| 23 | Алдаа зөрчлийн талаарх мэдээлэл бүртгэлийн дэвтэр | ширхэг | 0 |
| 24 | Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьсан бүртгэлийн дэвтэр | ширхэг | 0 |
| 25 | ЭУБ-12 | ширхэг | 3 |
| 26 | Иргэний бүртгэл болон иргэний баримт бичигт өөрчлөл, залруулга хийсэн иргэдийн бүртгэлийн дэвтэр /ИЗБ-1/ | ширхэг | 1 |

## ХОЁР. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2.1. Иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжийг аймгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулах ажлын чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмын хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон тус аймгийн 16 сум 2020 онд бүрэн холбогдсон байсан, 2021 оны 05 сарын 26-ны өдөр Хайрхандулаан, Нарийнтээл сумд бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдож, сумын бүртгэгчид онлайн сүлжээнд ажиллах эрхийг нээлгэсэн ба иргэний бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг онлайн сүлжээнд бүртгэж, бүх төрлийн лавлагааг сумандаа гарган иргэдэд түргэн шуурхай үйлчилж байна. Улсын бүртгэлийн 18 төрлийн үйлчилгээ, 20 төрлийн лавлагааны төлбөрийг ebarimt ашиглан төлөх боломж бүрдэж иргэдэд мэдээллийг хүргэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласнаар нийт 28 иргэн цахим төлбөрийн системийг ашиглаж, төлбөрийг цахимаар баталгаажуулав. Иргэн УБЕГазрын BURTGEL.MN сайтаар цахим архивын лавлагаа олгох программаас 14 төрлийн лавлагааг цахимаар хүлээн авах боломжийн талаар иргэдэд сурталчилгаа мэдээллийг хүргэж ажилласны үр дүнд иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн, хаясан гээгдүүлсэн иргэд /нийт 4 иргэн/ цахимаар захиалж баталгаажуулсан. Бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон 18 сумын бүртгэгч цахим архив ашиглах бүх төрлийн лавлагааг цахим архиваас гарган нотлох баримтандаа авч ашиглаж байна.

2.2. Иргэний улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу аймгийн хэмжээнд эрхлэн хөтлөх, хяналт тавих чиглэлээр:

2021 оны эхний хагас жилд сумаас иргэдийн гэр бүлийн байдлын бүртгэлээр 1744 ширхэг ИУБ маягтыг хүлээн авч, мэдээллийн санд оруулсан байна. Үүнээс төрөлт 1020 /үүнээс: эрэгтэй 549, эмэгтэй 471/, гэрлэлт 394 /үүнээс: анхны 363, дахин 30, сэргээсэн 1 /, гэрлэлт цуцлалт 23 /үүнээс: захиргааны журмаар 9, шүүхийн журмаар 14/, үрчлэлт 20 /үүнээс: Монгол Улсын иргэнд 20, ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчлөлт 31 /үүнээс: Монгол Улсын иргэнд 31/, эцэг тогтоолт 36 үүнээс: эрэгтэй 18, эмэгтэй 18, нас баралт 261 /үүнээс эрэгтэй 150, эмэгтэй 106/, тус тус байна. Нөхөн бүртгэлд бүртгүүлсэн нийт 63 иргэний мэдээлэл байгаагаас төрөлт 1 /үүнээс эрэгтэй 1, эмэгтэй 0/, нас баралт 5 /үүнээс эрэгтэй 1, эмэгтэй 4/ тус тус бүртгэж, ИУБ маягтуудыг бичиж, иргэний гэр бүлийн байдлын гэрчилгээ олгосон байна. Гэрчилгээ дахин олголт 36, үүнээс: Төрсний гэрчилгээ 36, гэрлэлтийн гэрчилгээ дахин олгосон. Сумдаас ирүүлсэн материалыг хянах явцад илэрсэн зөрчилтэй ИУБ маягтуудыг тухай бүр нь буцаан хүргүүлж, засварлуулж мэдээллийн санд үнэн зөвөөр тусгасан болно. Илэрсэн зөрчил дутагдлыг цаашид гаргахгүй байх талаар албан тоотоор болон улсын ахлах бүртгэгчийн мэдэгдэх хуудсаар анхааруулга, санамж, зөвлөмжийг өгч ажиллалаа. Илэрсэн зөрчлүүд нь ихэвчлэн бар код бүдэг хэвлэгдсэн, дутуу бичигдсэн, гарын үсэг зураагүй, тэмдэг дараагүй зэрэг шалтгаанаар буцаагдсан болно. Регистрийн дугаар 6-г сольж олголоо. Үүнд: Хяналтын байцаагчийн дүгнэлтээр-4 Улсын бүртгэгч-2 байна. Иргэний бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу иргэдэд шуурхай хүргэх, үйлчилгээний стандартыг мөрдөж, иргэдэд нээлттэй байдлаар үйлчилгээг чанартай хүргэж, иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай барагдуулж ажиллаж байна. 2021 онд нийт 2262 иргэнд иргэний үнэмлэх олгосноос шинээр 685 /үүнээс иргэний үнэмлэхийг цахим үнэмлэхээр сольсон 7, 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх авсан 676/, гадаадад бүртгүүлсэн 2,/ дахин 525 /үүнээс хаяж үрэгдүүлсэн 500, дүр төрх өөрчлөгдсөн 4, хүчинтэй байдлаа алдсан 9, овог нэр сольсон 4, төрсөн он тогтоолгосон 2, цахимаар захиалсан 6,/ сунгалтаар 1052/үүнээс: 25 насанд хүрсэн 524, 45 насанд хүрсэн 524, гадаадад өгсөн 4 иргэн тус тус байна. 2021 онд Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт авахыг хүссэн 117 иргэний материалыг УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газарт уламжлан олголоо. 2021 онд нийт Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 1273 иргэнд үйлчилгээ үзүүлснээс өөр аймаг нийслэлээс шилжиж ирсэн 213 үүнээс: насанд хүрэгч 141, хүүхэд 72, Аймаг доторх шилжилт хөдөлгөөний хүсэлт гаргасан нийт 1060 үүнээс: сум хооронд 382 /үүнээс насанд хүрэгч 247, 16-аас доош насны хүүхэд 135/, баг хооронд шилжин явах хүсэлт гаргасан нийт 678 иргэний /үүнээс насанд хүрэгчид 445, 16-аас доош насны хүүхэд 233/ баг хороонд шилжин явах хүсэлт гаргасан нийт 830 иргэний /үүнээс насанд хүрэгчид 544**,** 16-аас доош насны хүүхэд 286/, ИУБ-22 маягтыг мэдээллийн санд шивж оруулан, баталгаажуулсан байна.

2.3.Иргэний баримтын архивын сан бүрдүүлэлтийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд нийт 7908 ширхэг ИУБ маягтуудыг архивын санд байршуулснаас иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ИУБ маягтууд 1785 ширхэг, хуулбар бүртгэлээр хийсэн ИУБ маягт ИБТ-аас 50**,** сумдын улсын бүртгэгч нар 401 хуулбар бүртгэлийг УБЕГ-т албан тоотоор хүргүүлж санд оруулсан байна. ИУБ-31 маягт 1747ширхэг, ИУБ-21 маягт 2268

ширхэг үүнээс иргэний үнэмлэх дахин авалт 515, өөр аймаг, хотоос шилжиж ирсэн 1660 иргэний хувийн хэргийг тус тус байршуулсан байна. Аймгаас гадагш шилжилт хөдөлгөөн хийлгэсэн 100 хүний холбогдох хувийн хэргийг архивын сангаас хайн олж, холбогдох газрууд руу хүргүүлсэн байна. Нийслэл болон аймаг хотуудаас шилжиж ирсэн 213 иргэний ИУБ-22 маягтыг холбогдох хувийн хэргийн хамт архивын санд байршуулаад байна. Мөн аймаг дотор шилжилт хөдөлгөөн хийлгэсэн нийт 1660 иргэний ИУБ-22 маягтыг архивын санд байршуулаад байна. Архивын сангаас зөрчилтэй нийт 135 иргэний мэдээллийг татан авч шалгаснаас 135213 иргэний зөрчлийг арилгаж, буцаан байршуулсан байна. Зөрчил нь арилаагүй байршаагүй иргэний хувийн хэрэг байхгүй. Тайлангийн хугацаанд нийт 2560 ширхэг архивын лавлагаа олгосноос иргэнд 2368 ширхэг, албан тоотоор 106**,** албан хэрэгцээнд 57**,** веб лавлагаанд 11 тус тус байлаа.

2.4. Иргэний улсын бүртгэгч нарыг өдөр тутамд нэгдсэн арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллах чиглэлээр:

Иргэний бүртгэлийн тасгийн 5 улсын бүртгэгч, иргэний баримтын архивч, 19 сумын 20 улсын бүртгэгч нарын үйл ажиллагааг өдөр тутамд удирдан мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж ажиллав. Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажиллаж байна. КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, дэглэмийг мөрдөж хэрэгжүүлж, ажиллах талаар 19 суманд 5 удаа хэлтсийн даргаас үүрэг чиглэлийг хүргүүлж ажилласан. Сумдын улсын бүртгэгч нарын 2021 оны 1 дүгээр улиралд гүйцэтгэсэн ажлын талаар 7 хоног тутамд ирүүлсэн мэдээ тайланд судалгаа дүгнэлт хийж, ажлын ачааллыг харуулсан хүснэгтэн мэдээллийг албан хаагч нарт хүргүүллээ.

УБЕГазрын Мэдээлэл технологийн газраас тус аймгийн харьяалалтай нэг хаягт 10 ба түүнээс дээш сонгогч бүртгэгдсэн болон ижил овог нэртэй 270 иргэний мэдээллийн жагсаалтад Арвайхээр сумын 243 , Хархорин сумд 27 иргэн байгааг холбогдох сумын улсын бүртгэгч нар багийн Засаг дарга нартай хамтран мэдээллийг шалгаж, тодруулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Тус ажлын хүрээнд үндсэн хаяган дээрээ бүртгэлтэй боловч хаягтаа амьдраагүй байгаа 56 иргэнтэй холбогдон /багийг ажлын алба/ 180 буюу түүнээс хугацаагаар амьдарч байгаа газартаа шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх талаар мэдэгдсэн. Нэг хаягт 10 буюу түүнээс дээш сонгогч бүртгэгдсэн зарим хаягт нэг хашаанд 2-3 гэрт сонгуулийн насны 10 гаруй иргэн тус хаягт амьдарч байгаа нь үнэн болохыг шалгалтын явцад тогтоолоо. Дээрх хаягтаа амьдардаггүй 50 гаруй иргэдээс өөрийн өмчлөлийн байр, орон сууц, газраа бусдад худалдсан очсон газраа шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгээгүй иргэд байна. Эдгээрийг 80 орчим хувь нь Улаанбаатар хотод ажиллаж, амьдарч тэндээ суурьшсан иргэд байна. Нийслэл рүү шилжилт хөдөлгөөн хязгаарласантай холбоотой иргэний шилжилтээ хийлгээгүй иргэд байна.

Хархорин сумын улсын бүртгэгч болон багийн засаг дарга нартай хамтран 27 иргэний хаягийг тодруулж ажилласан бөгөөд хуучин хаяг дээр байсан 12 иргэний хаягийг шинэчилэн мэдээллийн санд тусгуулав.

Мэдээлэл технологийн газраас тус аймгийн харьяалалтай байсан  сонгуулийн насны хаяггүй 143 иргэний нэрсийн жагсаалт ирүүлсэнээс Арвайхээр сумын 65, бусад сумын 78 иргэн байсан байна. Сум дахь улсын бүртгэгч нарт багийн Засаг дарга,  ажлын албадтай хамтарч тухайн иргэд, ар гэртэй нь холбогдон амьдарч буй газрыг тодруулах, хаягийн зөрчлийг арилгуулах хугацаатай мэдэгдэл өгч ажиллав. Үүнээс 86 иргэний хаягийг олж тогтоон, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийж, мэдээллийн санд хаягтай болгосон. 36 иргэнтэй холбогдсон боловч хаягийн зөрчлөө арилгаагүй,  21 иргэнтэй холбогдож чадаагүй байна.

Иргэний бүртгэлийн системд ажиллах эрхийг иргэний улсын ахлах бүртгэгч-1, иргэний улсын бүртгэгч-3 ажилтанд нээлгэх саналыг хүргүүлж, эрх нээгдсэний дараа Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн системд ажиллах дадлага ажлыг зохион байгуулав. УБЕГазраас ирүүлсэн Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан ажиллав. Иргэний бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хугацаат ажил үүргийг дараах байдлаар хийж гүйцэтгэсэн. Улсын ахлах бүртгэгч, иргэний улсын бүртгэгч нар нь election.mn систем рүү үүссэн эрхийн дагуу нэвтэрч санал авах байрны жагсаалт дээр 19 сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолд заасан  Өвөрхангай аймгийн 13 дугаар тойргийн 110 хэсгийн санал авах байрыг шинээр бүртгэж оруулав. Тухайн хэсгийн нутаг дэвсгэрт хамаарах /бүртгэлийн нэгжид хамаарах/ хаягийн жагсаалт бүхий цонхноос хаягийн мэдээллийг тус бүр нэмж оруулж баталгаажуулав. Мэдээлэл технологийн газраас хэсгийн дугаарлалт хийгдэж, хэсэг  /13 дугаар тойргийн 110  хэсгийн/ оноогдох 75 иргэнд хэсгийн масс оноолт  хийгдсэн байсан. Хэсэг оноолт хийгдээгүй санал авах байрны хаяг бүртгэгдээгүй 43 иргэнд хэсэг оноолт хийсэн. Үүнд Арвайхээр  сумын 19 , Бат-Өлзий сумын 4, Богд сумын 5, Бүрд сум 1, Уянга сум 7, Хархорин сум 7  иргэн байсан 43 иргэнд хэсэг оноолтыг 2021 оны 03 дугаар сарын 24 нд хийж дуусгасан. Өвөрхангай аймгийн хэмжээнд 75463 иргэнд хэсэг оноолт хийгдэж дууссан. Тус системийн Хурлын тогтоол бүртгэх цэсийн Тогтоолын жагсаалтыг тогтоол нэмэх цонхоор 19 сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолыг хавсралтын хамт файл болгон нэмж бүртгэв. Дээрх үйл ажиллагааг хийж гүйцэтгэх явцад УБЕГазрын мэдээлэл технологийн газар, ИУБГазар, Интерактив компанитай холбогдон заавар зөвлөгөө авч ажиллав.

Тус аймгийн 13 дугаар тойргийн 110  хэсгийн санал авах байрны жагсаалтыг нэг бүрчилэн дахин тулгалт нягтлав. 19 сумын 110 хэсгийн санал авах байранд оноогдох хаягийг /баг нийлсэн, баг хуваагдсан/ дахин шалгасан. Иргэний улсын нар сумын төвийн сонгуулийн насны иргэдийн нэрсийг жагсаалтаар багийн Засаг дарга нараас авч мэдээллийн санд хаяг, овог нэр, регистрийн дугаарын тулгалтыг хийсэн. Сонгогчдын нэрсийн жагсаалтад хэсэггүй Уянга сумын Өлтийн 7 дугаар багийн 2 сонгогч нэмэгдэж ирснийг хэсэг оноолт хийсэн. Хэлтсийн 70322937 утсанд сонгогчийн нэрсийн жагсаалттай холбоотой гомдол, санал ирээгүй. Улсын бүртгэлийн ерөнхий газрын холбогдох утсанд тус аймгийн харъяалалтай 5 иргэний /Уянга-2, Арвайхээр-2, Тарагт-1/ нэрсийн жагсаалт ирснийг мэдээллийг нь санд шалгах, сум хариуцсан улсын бүртгэгч нартай холбогдон тус хаягтаа байдаг эсэхийг тодруулсан мэдээллийн санд байгаа хаягаар хэсэг оноолт хийгдсэн байна.

Сонгогчдын нэрсийн жагсаалт /13 тойрог 110 хэсэг, 75463 сонгогч / зөрчилгүй байна. Сонгогч шилжих хөдөлгөөнтэй холбогдуулан сумын улсын улсын бүртгэгч, Итгэмжлэгдсэн ажилтнууд нарыг өдөр тутамд арга зүйн удирдлагаар хангаж ажиллав. Сонгогч шилжих хөдөлгөөнийг 2021 оны 05 дугаар сарын 15-наас эхэлж, 2021 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 00.00 цаг хүртэл явагдсан. Өвөрхангай аймгийн 19 сумын 110 хэсгийн хороодод сонгогч шилжүүлэг хийгдсэн нийт 1667 сонгогч шилжилтийг хийж лавлагаа хэвлэлээ. Үүнээс сонгогч шилжин ирсэн 820, шилжин явсан 827, нас барсан 17, Иргэний бүртгэлийн өөрчлөлтэй холбоотой 3 тус тус хийгдсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц бүртгэлийг Өвөрхангай аймагт ямар нэгэн зөрчилгүй, амжилттай зохион байгууллаа.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудын судалгааг сумын ЗДТГазартай хамтран хийж, 110 хэсгийн хороонд ажиллах 110 итгэмжлгэдсэн ажилтны судалгааг гарган аймаг дахь Тагнуулын хэлтэст хүргүүлсэн, Тагнуулын хэлтсээс ирсэн зөвшөөрлийн дагуу итгэмжлэгдсэн ажилтныг томилсон хэлтсийн даргын тушаал 2021.04.17-нд гарч, нууцын баталгаа авах, гэрээ хийгдэх, үнэмлэх олгох ажил зохион байгуулагдав. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 13 дугаар тойргийн 110 хэсгийн хороонд ажиллах 110 итгэмжлэгдсэн ажилтны сургалтын хөтөлбөрийн хэлтсийн даргаар батлуулан, итгэмжлэгдсэн ажилтнуудад хөтөлбөрийг цахимаар хүргүүлэв. Сургалтын материалыг сум дахь улсын бүртгэгч нарт цахимаар хүргүүлэн итгэмжлэгдсэн ажилтны тоогоор хувилан 3 хоногийн өмнө хүргүүлэн хууль, тогтоомж, журмыг судлуулах, танилцуулах ажлыг зохион байгуулав. Сургалтыг хөдөөний 18 суманд цахимаар хийхээр төлөвлөж, мэдээлэл технологийн ажилтан Л.Отгонболд сургалт явуулах эрхийг авч, сум дахь улсын бүртгэгч нартай холбогдох туршилт хийж бэлэн болгов. Арвайхээр сумын итгэмжлэгдсэн ажилтнуудад хорио цээрийн дэглэмийг хангаж танхимаар зохион байгуулав. 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 15.00 цагт цахим сургалтыг эхэлж, 18.00 цагт дуусгав. 19 сумын 110 хэсгийн хорооны дэргэд ажиллах 110 итгэмжлэгдсэн ажилтан сумдын бүртгэгч нарт сургалтыг зохион явуулав. Сургалтыг хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэдмаа, Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, ЭХЭБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Болор-Эрдэнэ, Итгэмжлэгдсэн ажилтны гэрээ байгуулах, нууцын баталгаа, Төрийн албаны ёсзүйн асуудал, Иргэний бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Н.Түдэвмаа Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах хүргүүлэх, сонгогч шилжих журам, Итгэмжлэгдсэн ажилтаны чиг үүрэг, сэдвүүдээр сургалтыг зохион байгуулав. Тагнуулын газраас Төрийн нууц, Албаны нууцын тухай хууль тогтоомж, мэдээллийн сангийн аюулгүй байдлын талаар аймаг дахь Тагнуулын хэлтсийн ажилтан мэргэжилтэн Ж.Ууганбаяр мэдээлэл өгч хамтран ажилласан. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны ирц бүртгэлийн программын сургалтыг зохион байгуулах ажлыг УБЕГазраас сургалтын багийнхантай хамтран зохион байгуулав. Сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулж, 110 хэсгийн хороонд ажиллах 110 итгэмжлэгдсэн ажилтнууд, улсын бүртгэгч нарыг оролцуулав. Итгэмжлэгдсэн ажилтнуудад Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар бүртгэлийн байгууллагын хүлээсэн үүргийн сургалтын багийн

ахлагч  Мөнхцэцэг, сургалтын үеэр болон санал авах өдрүүдэд анхаарч ажиллах асуудлын талаар Сонгинохайрхан дүүргийн МТИнженер Энхтуул хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэдмаа, улсын ахлах бүртгэгч Н.Түдэвмаа, Болор-Эрдэнэ нар чиглэл, зөвлөмжийг өгч ажиллав. Сонгогч шилжих болон иргэний бүртгэлийн өөрчлөлтөөр гарсан 1667 лавлагааг хэсэг тус бүрээр оруулан, 2021 оны 5 дугаар сарын 31-ний өглөөний 09.00 цагаас СНЖагсаалтыг хэвлэх, программ түгжих үйл ажиллагаанд шилжин, 17.30 дуусгасан байна.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх ажлын хэсгийг хэлтсийн даргын тушаалаар баталж, хэвлэх эрхийг иргэний улсын ахлах бүртгэгч, иргэний улсын 5  бүртгэгч, Мэдээлэл технологийн ажилтан гэсэн 6 хүнд эрх нээлгэхээр Иргэний улсын бүртгэлийн газарт тоотыг хүргүүлэн эрх нээлгэсэн. 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн оройны 19.00 –цагаас эхлэн бэлтгэл ажлыг хангах/6 компьютер, принтер, цаас, цаасан уут, цавуу зэрэг бусад хэрэгсэлийг /ажлыг зохион байгуулав. Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх үйл ажиллагаа нь 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн өглөөний 08 цаг 00 минутанд хэлтсийн даргын 207 тоот өрөөнд хэвлэж эхлэв.

Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэдмаа, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Н.Түдэвмаа, Эд хөрөнгийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Болор-Эрдэнэ, иргэний улсын бүртгэгч Ц.Төмөрсүх, Иргэний улсын бүртгэгч С.Мягмарсүрэн, иргэний улсын бүртгэгч Ч.Цэрэндорж, хуулийн этгээдийн улсын бүртгэгч У.Должинсүрэн, иргэний бүртгэлийн архивч Д.Цэрэннадмид мэдээллийн технологийн ажилтан Л.Отгонболд, нар  хийж гүйцэтгэлээ.

Хэвлэх үйл ажиллагаанд 6 тоног төхөөрөмжийг зэрэг ажиллуулан хэвлэсэн бөгөөд хэвлэх явцад Богд сумын 3 дугаар багийн сонгогчдийн нэрсийн жагсаалтаас 1, Нарийнтээл сумын сонгогчийн нэрсийн жагсаалтаас 5, Нарийнтээл сумын сонгогчийн нэрсийн жагсаалтаас 1, Хайрхандулаан сумын сонгогчийн нэрсийн жагсаалтаас 1, Арвайхээр сумын 10 дугаар багийн сонгогчийн нэрсийн жагсаалтаас 21, Хужирт сумын 5 дугаар багийн сонгогчийн нэрсийн жагсаалтаас 5, Гучин-Ус сумын 4 дүгээр багийн нэрсийн жагсаалтаас 1, Арвайхээр сумын 10 дугаар багийн нэрсийн жагсаалтаас 19, Бүрд сумын 1 дүгээр багийн сонгогчийн нэрсийн жагсаалтаас 25 хуудас тус бүр принтерийн халалтаас үүссэн алдаа болон хор бүдэг хэвлэгдсэн 89 хуудас материалыг тухай бүрт нь тэмдэглэн үйлдэн хураан авч Хяналтын улсын байцаагч хүчингүй тэмдэглэгээ хийн дугтуйлж лацдан баримтжуулж хадгалсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 110 хэсгийн хороонд хаягтай Сонгогчдын нэрсийн жагсаалтыг  тус бүр 2 хувь үйлдэв. Сонгогчдын нэрсийн жагсаалтад 75463 сонгогч бүртгэлтэй бөгөөд түр хасав тэмдэглэгээтэй 1119 сонгогч байна. Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх үйл ажиллагаа 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 15 минутанд дууссан болно.

Дээрх бүрэлдэхүүнийг байлцуулан 10 цаг 40 минутанд тус аймгийн 110 хэсгийн хорооны хэсгийн хороо тус бүрээр 2 хувь хэвлэсэн сонгогчийн нэрсийн жагсаалтыг тулган шалгаж, баталгаажуулах, битүүмжлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд уг ажлыг 14 цаг 35 минутанд дуусгав. Энэхүү ажлын хүрээнд хэсгийн хороо тус бүрээр 2 хувь сонгогчийн нэрсийн жагсаалтыг

тус бүр бор дугтуйнд хийж битүүмжлэн хаягласан болно. Хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэдмаа сонгогчийн нэрсийн жагсаалт  хэвлэх үйл ажиллагаа дууссаны дараа хэлстийн даргын 207 тоот өрөөний 2 цонхны салхивчийг лацдан тэмдэглэл үйлдсэн. Мөн хэсгийн хороо тус бүрээр 2 хувь хэвлэсэн, дугтуйлж, лацдсан сонгогчийн нэрсийн жагсаалтыг хэлтсийн даргын өрөөнд шүүгээнд хийн тэмдэглэл үйлдэн баримтжуулж лацдаж хадгалсан болно. Арвайхээр сумын 13 хэсгийн хорооны дарга, итгэмжлэгдсэн ажилтан, сумын сонгуулийн хорооны дарга нарыг 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 18.00 цагаас Арвайхээр сумын Засаг Даргын тамгын газрын 206 тоот өрөөнд хэсгийн хороодод сонгогчдын нэрсийн жагсаалтыг хүлээлгэн өгсөн.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хуулийн дагуу хэсгийн хороодод хүлээлгэн өгөх ажлын хэсгийг хэлтсийн дарга томилж, маршрутыг батлан, 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн өглөөний 06.00 цагаас 3 чиглэлд гаргахаар болсон. Улсын бүртгэлийн хэлтсийн дарга хэлтсийн  ӨВА11-14  дугаартай автомашинтай  Уянга, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин сумдад, Иргэний улсын ахлах бүртгэгч Н.Түдэвмаа Засаг даргын тамгын газрын ӨВО00-04 дугаартай автомашинтай Өлзийт, Есөнзүйл, Бүрд, Баян-Өндөр, Сант , Баянгол, Төгрөг сумдад, Улсын бүртгэгч Ч.Цэрэндорж Засаг даргын орлогчийн ӨВА00-02 дугаартай автомашинтай Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Тарагт сумдад СНЖагсаалтыг хүлээлцэх ажлыг зохион байгуулав.

2.5.Иргэний бүртгэлийн чиглэлээр хэрэгжүүлсэн шинэлэг ажлуудаас:

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал болон зарим иргэдийн бичиг баримтын бүрдэл дутуу тохиолдолд утсаар мэдэгдэж, хугацааг хэмнэж ажилласнаар иргэдийн сэтгэл хангамжийн байдал эрс дээшилсэн.

Шинээр баг байгуулагдсанаар хаягийн өөрчлөлт хийлгэх шаардлагатай болсон тохиолдолд орон нутгийн шийдвэрийг үндэслэн УБЕГ-ын МТГ-т тухай бүр мэдэгдэж, хаяг нэмүүлэх асуудлыг шуурхай авч хэрэгжүүлж хэвшсэн.

Иргэний цахим үнэмлэхний баталгаажуулалтыг сумдын бүртгэгч нартай өдөр тутам утсаар холбогдон, мэдээллийг тулган шалгаж, баталгаажуулж байна.

УБЕГ-ын холбогдох бүртгэгч нартай өдөр тутамд холбогдон, шаардлагатай цаг үеийн асуудлуудыг харилцан зөвшилцөж, асуудлыг шийдвэрлэж байна.

Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар тус бүрдээ аймгийн хэмжээний 19 сумдыг хариуцан ажиллаж өдөр тутамд нь мэдээллээр ханган ажиллаж байна

